“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ....3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ....3
СОНГОСОН БАЙДАЛ....3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ....6
ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ....7
4.1. Зорилгод хүрэх байдал....10
4.2. Практикт хэрэгжих боломж....11
4.3. Ойлгомжтой байдал....14
4.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал....15
4.5. Зардал....16
4.6. Харилцан уялдаа....18
ТАВ. ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ....19
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ....20
ДОЛОО. АШИГЛАСАН МАТЕРИАЛ....20

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалын 1.4-т заасан дараах үе шатны дагуу хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж боловсруулах.

Хуулийн төсөл нь орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд жендэрийн тэгш төлөөллийг хангах, нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал болон тойрог тус бүр дэх хүйсийн төлөөллийг зохицуулахад чиглэж байна. Тодруулбал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан нам, эвслээс нэр дэвшүүлэхэд тавигдах аль нэг хүйсийн нэр дэвшигчийн доод хувийг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлэх, 29.4 дэх хэсэгт нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, 29.5 дахь хэсэгт гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийг хангах шаардлага тогтоохоор тусгажээ. Мөн эдгээр шаардлагыг зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт нэмэхээр зохицуулсан байна.

Иймд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ жендэрийн тэгш төлөөллийг хангах зорилгод хүрэх байдал, санал болгож буй зохицуулалтыг сонгуулийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх практик боломж, зохицуулалтын ойлгомжтой байдал, оролцогч талуудын хүлээн зөвшөөрөх байдал, хэрэгжилттэй холбоотой зардал, бусад хууль тогтоомжтой харилцан уялдах байдлыг тус тус үнэлэх нь зүйтэй гэж үзэв.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан аргачлалд заасан 6 шалгуур үзүүлэлтээс дараах шалгуур үзүүлэлтийг сонгов. Аргачлалын 2.9-д төслийн онцлогоос хамааран нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болохоор заасан. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Зардал;
6. Харилцан уялдаа.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалд тусгасан үндэслэл, шаардлагатай нийцэж байгаа эсэх. Тухайлбал: 29.2 дахь хэсэгт нэр дэвшигчдийн хүйсийн квотыг 20-оос 40 хувь болгон нэмэгдүүлэх; 29.4 дэх хэсэгт нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах; 29.5 дахь хэсэгт гурав ба түүнээс дээш мандаттай тойрогт хүйсийн төлөөллийн доод хувийг тогтоох зохицуулалт. Эдгээр зохицуулалт нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгод хүрэх боломжтой эсэх.	Зорилгод дүн шинжилгээ хийх. Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, холбогдох судалгаа болон одоогийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжлэх. Квотын хэмжээг нэмэгдүүлэх, жагсаалтын дараалал тогтоох, тойрог тус бүрд хүйсийн төлөөллийг хангах зохицуулалт зорилгод хүрэхэд хангалттай эсэхийг үнэлэх.
2	Практикт хэрэгжих боломж	Нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагаандаа 29.2, 29.4, 29.5-д заасан шаардлагыг хэрэгжүүлэх боломж; сонгуулийн байгууллага эдгээр шаардлагыг хянах, зөрчил илрүүлэх, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах ажиллагааг хэрэгжүүлэх боломж. Мөн 32.1.10, 32.1.11-д заасан бүртгэхээс татгалзах үндэслэл бодит нөхцөлд хэрэгжих боломжтой эсэх.	Практикт турших. Өмнөх сонгуулийн нэр дэвшүүлэлтийн мэдээлэлд тулгуурлан 40 хувийн квот, жагсаалтын сөөлжлүүлсэн дараалал болон тойрог тус бүрийн хүйсийн төлөөллийн шаардлагыг жишиг тохиолдлоор турших. Нэр дэвшигчийн тоо тэгш, сондгой байх, нэр дэвшигч татгалзах, нэр дэвшигчийг солих зэрэг нөхцөлд зохицуулалт хэрхэн хэрэгжихийг шалгах. Сонгуулийн байгууллагын бүртгэл, хяналтын үйл ажиллагаанд шаардагдах хүний нөөц, мэдээллийн систем, хугацаа, эрх хэмжээний хүрэлцээг үнэлэх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмэх 29.4, 29.5, 32.1.10, 32.1.11 дэх заалт	Ойлгомжтой байдлыг шалгах.

		болон 2 дугаар зүйлээр 29.2 дахь хэсэгт оруулж буй өөрчлөлтийн найруулга, агуулга хоёрдмол утгагүй эсэх. Тухайлбал, 29.5 дахь хэсгийн “40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна” гэсэн хэллэг нь аль нэг хүйсийн төлөөллийн доод хэмжээг тогтоож байгаа эсэх, эсхүл хүйс тус бүрийн төлөөллийг 40 хувиас доошгүй байлгах шаардлага тавьж байгаа эсэх; 32.1.10, 32.1.11-д заасан зөрчил гарсан тохиолдолд ямар хүрээний нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах нь тодорхой эсэх.	Хуулийн нэр томьёо, өгүүлбэрийн бүтэц, хууль зүйн найруулгад дүн шинжилгээ хийх; заалтуудыг өөр өөр нөхцөлд тайлбарлан шалгах; хууль хэрэглэгч, сонгуулийн байгууллагын ажилтнаар ойлгомжтой байдлыг туршуулах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалт нь нам, эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн байгууллага болон сонгогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлөх; нэр дэвшүүлэх ажиллагаанд үүсэх боломж, хязгаарлалт; эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө. Мөн квотын зохицуулалт нь нэр дэвшигчдийн сонгогдох эрх, сонгогчдын сонголт хийх эрхтэй хэрхэн уялдах асуудал.	Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах. Нам, эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон сонгогчдын төлөөллийг хамруулсан ярилцлага, санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах. Оролцогч талуудын дэмжлэг, болгоомжлол, хэрэгжилтэд тулгарч болзошгүй хүндрэл, эрхийн хязгаарлалтын талаарх байр суурийг харьцуулан судлах.
5	Зардал	Төсөв, нам, эвсэл, сонгуулийн байгууллагад үүсэх зардал	Зардлын тооцоо хийх
6	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Аргачлалд дээрх шалгуур үзүүлэлт тус бүрт “зорилгод дүн шинжилгээ хийх”, “практикт турших”, “ойлгомжтой байдлыг шалгах”, “хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх”, “зардлын тооцоо хийх”, “хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн харгалзах шалгах хэрэгслийг тогтоосон байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь гурван зүйлтэй бөгөөд үндсэн зохицуулалт нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан нэр дэвшигчдийн хүйсийн квотыг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлэх, мөн нэр дэвшигчдийг жагсаалтад эрэгтэй, эмэгтэйгээр сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийн доод хэмжээг тогтоох замаар улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд хүйсийн тэнцвэртэй төлөөллийг хангахад чиглэж байна.

Түүнчлэн хуулийн төслөөр дээрх шаардлагыг зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах эрх зүйн үндэслэлийг тодорхойлж, хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхээр тусгасан. Хуулийн төслийг 2028 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр зохицуулжээ.

Аргачлалын 3.1, 3.2-т заасны дагуу хуулийн төслийн зорилгод хүрэхэд шууд нөлөөлөх, эрх зүйн болон практик үр дагавар үүсгэх гол ач холбогдолтой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлэх шаардлагатай. Иймд хуулийн төслийн дараах зохицуулалтыг үнэлгээний үндсэн хэсэг болгон сонгов.

3.1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд дараах агуулгатай 29.4, 29.5 дахь хэсэг, 32 дугаар зүйлд 32.1.10, 32.1.11 дэх заалтыг тус тус нэмэх зохицуулалт юм. Үүнд:

- 29.4 дэх хэсэгт нам, эвслээс тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах;
- 29.5 дахь хэсэгт гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нам, эвслээс нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байх шаардлага тогтоох;
- 32.1.10 дахь заалтад 29.2-т заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд нийт нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах;
- 32.1.11 дэх заалтад 29.4, 29.5-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл тусгах.

Эдгээр зохицуулалт нь хүйсийн квотыг зөвхөн тоон үзүүлэлтээр тогтоохоос гадна нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал болон сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийг хангах, улмаар шаардлагын хэрэгжилтийг бүртгэлийн шатанд хянах эрх зүйн механизмыг бүрдүүлэхэд чиглэж байна.

Энэ нь хуулийн төслийн зорилгыг шууд хэрэгжүүлэх үндсэн зохицуулалт юм.

3.2. Хуулийн төслийн 2 дугаар зүйл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан “20” гэснийг “40” болгон өөрчлөх зохицуулалт.

Энэ нь нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд баримтлах хүйсийн квотыг нэмэгдүүлж, нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй төлөөллийг хангах үндсэн шаардлагыг тогтоож байна. Уг зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ квотын хэмжээг нэмэгдүүлснээр нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа болон сонгогдох боломжид үзүүлэх нөлөөг авч үзнэ.

3.3. Хуулийн төслийн 3 дугаар зүйл

Хуулийг 2028 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөх зохицуулалт.

Энэ нь үндсэн квотын зохицуулалтыг хэзээнээс хэрэгжүүлэхийг тогтоох бөгөөд улс төрийн намууд, сонгуулийн байгууллагад зохион байгуулалтын бэлтгэл хийх боломж олгоход чиглэж байна.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зорилго нь орон нутгийн Хурлын сонгуульд улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангаж, улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэртэй төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа эсэхийг үнэлнэ. Энэ хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр 29.4, 29.5 дахь хэсэг, 32.1.10, 32.1.11 дэх заалтыг нэмсэн, 2 дугаар зүйлээр 29.2 дахь хэсгийн квотыг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлсэн зохицуулалтыг хамруулна. Тухайлбал, квотын хэмжээг нэмэгдүүлэх, нэр дэвшигчдийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай тойрогт хүйсийн төлөөллийн доод хэмжээг тогтоох, эдгээр шаардлагыг зөрчсөн тохиолдолд бүртгэхээс татгалзах зохицуулалт нь хуулийн төслийн зорилгод хүрэхэд хангалттай эсэхийг үнэлнэ.	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмсэн 29.4, 29.5 дахь хэсэг болон 32.1.10, 32.1.11 дэх заалт, 2 дугаар зүйлээр өөрчилсөн 29.2 дахь хэсгийн шаардлагыг улс төрийн нам, эвсэл хэрэгжүүлэх,	Практикт турших. Өмнөх сонгуулийн нэр дэвшүүлэлтийн

		сонгуулийн байгууллага хянах, нэр дэвшигчийг бүртгэх ажиллагаанд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлнэ. Тухайлбал, нэр дэвшигчдийн жагсаалтад хүйсийг сөөлжлүүлэн байрлуулах, тойрог тус бүрийн квотыг тооцох, нэр дэвшигч татгалзах болон солигдох үед шаардлагыг хангах, зөрчил гарсан тохиолдолд бүртгэхээс татгалзах ажиллагааны хэрэгжих боломжийг авч үзнэ. Мөн 2028 оны сонгууль хүртэл шаардлагатай журам, мэдээллийн систем, хүний нөөц, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах боломжийг үнэлнэ.	мэдээлэлд үндэслэн квот, жагсаалтын дараалал, тойрог тус бүрийн шаардлагыг жишиг нөхцөлд турших. Нэр дэвшигчийн тоо тэгш, сондгой байх, нэр дэвшигч татгалзах, солигдох зэрэг тохиолдлыг загварчлан шалгах. Сонгуулийн байгууллагын бүртгэл, хяналтын боломж, хэрэгжилтийн хугацаа, хүний нөөц, мэдээллийн системийн хүрэлцээг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулна. Тухайлбал, 29.2 дахь хэсгийн “40-өөс доошгүй хувь” гэсэн квотын шаардлага, 29.4 дэх хэсгийн нэр дэвшигчдийг сөөлжлүүлэн байрлуулах журам, 29.5 дахь хэсгийн тойрог тус бүрийн хүйсийн төлөөллийн шаардлага, 32.1.10, 32.1.11 дэх заалтын бүртгэхээс татгалзах үндэслэл нь ойлгомжтой, тодорхой, хоёрдмол утгагүй томьёологдсон эсэхийг үнэлнэ. Ялангуяа 29.5 дахь хэсгийн “40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна” гэсэн хэллэг нь хүйс тус бүрийн төлөөллийн доод хэмжээг тогтоож байгаа эсэхийг тодорхой илэрхийлж байгаа эсэх, 32.1.10, 32.1.11 дэх заалтаар ямар хүрээний нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах нь тодорхой эсэхийг шалгана	Хууль тогтоомжийн тухай хууль болон хуулийн төсөл боловсруулах, үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултаар хуулийн төслийн найруулга, нэр томьёо, зүйл, хэсэг, заалтын тодорхой байдлыг шалгах. Өөр өөр нөхцөлд тайлбарлан турших.

4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалт нь иргэд, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн байгууллага болон бусад оролцогч талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлөхийг үнэлнэ. Тухайлбал, квот нэмэгдүүлэх, нэр дэвшигчдийн жагсаалтын дарааллыг зохицуулах нь нам, эвслийн нэр дэвшүүлэх эрх, нэр дэвшигчдийн сонгогдох эрх, иргэдийн сонгох эрхэд хэрхэн нөлөөлөх; эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн улс төрийн оролцооны тэгш боломжийг хангах зорилгод нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Мөн шинэ шаардлагыг хэрэгжүүлэхэд нам, эвсэл болон сонгуулийн байгууллагад үүсэх хүндрэл, оролцогч талуудын хүлээлт, байр суурийг үнэлнэ.	Оролцогч талуудын эрх ашиг, хэрэгцээ шаардлага, нийгмийн хүлээлтэд нийцэж байгаа эсэхийг судлах. Улс төрийн нам, эвсэл, сонгуулийн байгууллага, нэр дэвшигч, иргэний нийгмийн байгууллага болон сонгогчдын төлөөллийг хамруулсан ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулна. Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн бусад зохицуулалттай нийцэж байгаа эсэх, зүйл, заалтын хооронд зөрчил, давхардал, хийдэл үүсгэх эсэхийг үнэлнэ.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах
6	Зардал	Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсөв, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэх эсэхийг үнэлнэ. Хуулийн төсөл нь шинэ байгууллага байгуулах, шинэ орон тоо бий болгох, төрийн шинэ үйлчилгээ бий болгох, төрийн албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх зохицуулалт агуулаагүй тул улсын болон орон нутгийн төсөвт их хэмжээний шууд нэмэлт зардал үүсгэхгүй. Нэр дэвшигч бүртгэх мэдээллийн системд 40 хувийн шаардлагыг тусгахтай холбоотой	Хуулийн төсөл хэрэгжихэд шаардагдах зардал, санхүүгийн эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийх

		техникийн тохируулга хийх зардал гарч болох боловч энэ нь одоо байгаа сонгуулийн зохион байгуулалт, бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжтой байна. Улс төрийн нам, эвсэл нь нэр дэвшигч сонгон шалгаруулах, эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн оролцоог хангах, дотоод зохион байгуулалт хийхтэй холбоотой тодорхой хэмжээний зардал гаргаж болох боловч уг зардал нь хуулиар тогтоосон татвар, төлбөр, хураамжийн шинжтэй биш байна. Иргэдэд нэмэлт татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний төлбөр бий болгохгүй. Иймд хуулийн төсөл нь улсын төсөв, орон нутгийн төсөв болон иргэдэд мэдэгдэхүйц шууд санхүүгийн ачаалал үүсгэхгүй бөгөөд хэрэгжилттэй холбоотой зардлыг одоо байгаа төсөв, зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэхийг үнэлнэ.	

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. Зорилгод хүрэх байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ, шаардлагад хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нийцэж байгаа эсэх, санал болгож буй зохицуулалтууд нь тодорхойлсон асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийн зорилго нь орон нутгийн Хурлын сонгуульд улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах, нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй төлөөллийг нэмэгдүүлэх, улмаар орон нутгийн түвшний улс төрийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Энэ зорилгын хүрээнд хуулийн төсөлд дараах үндсэн зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- 29.2 дахь хэсэгт: Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн аль нэг хүйсийн төлөөллийг 20-оос доошгүй байхаар тогтоосон зохицуулалтыг 40-өөс доошгүй хувь болгон нэмэгдүүлэх;
- 29.4 дэх хэсэгт: Нам, эвслээс тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах;

- 29.5 дахь хэсэгт: Гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нам, эвслээс нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тогтоох;
- 32.1.10, 32.1.11 дэх заалтад: Дээрх нэр дэвшүүлэх ажиллагааны журам болон хүйсийн төлөөллийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг тусгах.

Ийнхүү хуулийн төсөл нь хүйсийн квотын хэмжээг нэмэгдүүлэхээс гадна нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал, сонгуулийн тойрог тус бүрийн хүйсийн төлөөлөл болон эдгээр шаардлагын хэрэгжилтийг хангах эрх зүйн механизмыг бүрдүүлэхээр зохицуулжээ.

Одоогийн нөхцөл байдал:

Одоогийн хуулийн 29.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байхаар зохицуулсан. Гэвч 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн 17.9 хувь, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн 28.5–28.8 орчим хувь нь эмэгтэй байсан нь нэр дэвшигчийн 20 хувийн доод босго нь сонгогдсон төлөөлөгчийн бодит жендэрийн төлөөллийг хангалттай түвшинд хүргэх баталгаа болж чадахгүй байгааг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, нэр дэвшигчдийн хүйсийн төлөөлөлд тодорхой хэмжээний квот тогтоосон боловч уг квот нь нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал, сонгуулийн тойрог тус бүрийн төлөөллийн харьцааг зохицуулаагүй нөхцөлд эмэгтэйчүүдийн нэр дэвших боломж болон сонгогдох бодит боломжийн хооронд зөрүү үүсэх эрсдэлтэй байна.

Мөн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2028 оны ээлжит сонгуулиас эхлэн нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байхаар шаталсан зохицуулалт тогтоосон бөгөөд орон нутгийн сонгуулийн хувьд 20 хувийн босго хэвээр байгаа нь сонгуулийн хууль тогтоомж дахь хүйсийн төлөөллийн шаардлагын түвшин, бодлогын уялдааг хангах хэрэгцээ байгааг харуулж байна.

Иймд зөвхөн нэр дэвшигчдийн нийт тоонд хамаарах квотын хэмжээг нэмэгдүүлэхээс гадна нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал, тойрог тус бүрийн хүйсийн төлөөллийг зохицуулах, эдгээр шаардлагын хэрэгжилтийг хангах эрх зүйн хариуцлагын механизмыг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

Үнэлгээ:

Хуулийн төслийн зохицуулалтуудыг хэрэгжүүлснээр дараах эерэг үр нөлөө гарах боломжтой гэж үзэв.

<u>1. Хүйсийн квотыг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлэх зохицуулалтын үр нөлөө</u>

29.2дахь хэсэгт заасан квотын хэмжээг нэмэгдүүлснээр:

- нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд аль нэг хүйсийн төлөөллийн доод хэмжээг нэмэгдүүлнэ;

- эмэгтэйчүүдийн нэр дэвших боломжийг эрх зүйн хувьд өргөжүүлнэ;
- улс төрийн нам, эвслийн нэр дэвшигч сонгон шалгаруулах ажиллагаанд хүйсийн тэнцвэрийг хангах шаардлагыг нэмэгдүүлнэ;
- сонгуулийн өрсөлдөөнд оролцох нэр дэвшигчдийн хүйсийн харьцааг илүү тэнцвэртэй болгох нөхцөл бүрдүүлнэ.

2. Нэр дэвшигчдийн жагсаалтыг сөөлжлүүлэн байрлуулах зохицуулалтын үр нөлөө

29.4 дэх хэсэгт заасан эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах шаардлага нь зөвхөн нэр дэвшигчдийн тоон харьцааг хангахаас гадна нэр дэвшигчдийн жагсаалтын дараалалд хүйсийн тэнцвэрийг тусгах ач холбогдолтой.

Ингэснээр:

- нэр дэвшигчдийн жагсаалтад нэг хүйсийн нэр дэвшигч дараалан байрших нөхцөлийг хязгаарлана;
- эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн нэр дэвших боломжийг жагсаалтын дарааллын түвшинд тэнцвэржүүлэх нөхцөл бүрдэнэ;
- нам, эвслийн нэр дэвшүүлэх ажиллагаанд хүйсийн тэнцвэрийг хангах нэмэлт баталгаа бий болно.

3.Сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийн шаардлага тогтоох зохицуулалтын үр нөлөө

29.5 дахь хэсэгт заасан гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийн 40 хувийн шаардлага тогтоосноор нийт нэр дэвшигчдийн хэмжээнд квот хангагдсан боловч тодорхой тойрогт нэг хүйсийн нэр дэвшигчийн төлөөлөл хэт бага байх эрсдэлийг бууруулахад чиглэнэ. Ингэснээр:

- хүйсийн төлөөллийн шаардлагыг зөвхөн нам, эвслийн нийт нэр дэвшигчийн хүрээнд бус, сонгуулийн тойргийн түвшинд хангах нөхцөл бүрдэнэ;
- тойрог бүрд нэр дэвшигчдийн хүйсийн төлөөллийг харьцангуй тэнцвэртэй байлгах эрх зүйн шаардлага бий болно;
- нэр дэвшигчдийн хүйсийн төлөөлөл сонгуулийн тойрог хооронд жигд бус хуваарилагдах эрсдэлийг бууруулах боломжтой.

4. Нэр дэвшүүлэх ажиллагааны шаардлагыг зөрчсөн тохиолдолд бүртгэхээс татгалзах зохицуулалтын үр нөлөө

32.1.10, 32.1.11 дэх заалтад тусгасан зохицуулалт нь хүйсийн квот болон нэр дэвшүүлэх ажиллагааны шаардлагыг зөвхөн тунхагласан шинжтэй байлгахгүйгээр хэрэгжилтийг нь сонгуулийн байгууллагын бүртгэлийн шатанд хянах эрх зүйн үндэслэл бүрдүүлнэ. Ингэснээр:

- нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагаанд хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлэх эрх зүйн үүрэг хүлээнэ;
- сонгуулийн байгууллага шаардлагын хэрэгжилтийг хянах, зөрчил гарсан тохиолдолд хуульд заасан үр дагаврыг хэрэглэх боломжтой болно;
- квот болон жагсаалтын дарааллын зохицуулалтын хэрэгжилтийг хангах эрх зүйн баталгаа бий болно.

Гэхдээ бүртгэхээс татгалзах зохицуулалтыг хэрэглэхдээ ямар зөрчилд ямар хүрээний нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах, уг шийдвэрийн эрх зүйн үр дагавар ямар байхыг тодорхой тогтоох шаардлагатай. Энэ нь нэр дэвшигчдийн сонгогдох эрх болон сонгогчдын сонголт хийх боломжид нөлөөлөх тул эрх зүйн тодорхой байдлыг хангах нь чухал юм.

5.Хуулийн зохицуулалтыг 2028 оны ээлжит сонгуулиас дагаж мөрдөх зохицуулалтын үр нөлөө

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд заасан дагаж мөрдөх хугацаа нь улс төрийн нам, эвсэл болон сонгуулийн байгууллагад шинэ зохицуулалтад нийцүүлэн дотоод журам, нэр дэвшигч сонгон шалгаруулах ажиллагаа, бүртгэл, хяналтын тогтолцоогоо бэлтгэх боломж олгох ач холбогдолтой.

Гэхдээ энэ хугацаанд холбогдох журам, аргачлал, мэдээллийн системийн өөрчлөлт, сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах боломжтой эсэхийг мөн харгалзан үзэх шаардлагатай.

4.2. Практикт хэрэгжих боломж

Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын боломж байгаа эсэхийг үнэлэв.

Хуулийн төслийн хэрэгжилтэд:

- улс төрийн нам;
- намын орон нутгийн байгууллага;
- сонгуульд оролцох нам, эвсэл;
- нам, эвслээс нэр дэвшигч;
- Сонгуулийн ерөнхий хороо;
- сонгуулийн хороод голлон оролцоно.

Хэрэгжүүлэх боломж: Хуулийн төслийн хүрээнд улс төрийн намууд нэр дэвшигчээ тодруулах, нэр дэвшүүлэхдээ тухайн тойрогт нэр дэвшигчдийн хүйсийн төлөөллийн 40 хувийн доод шаардлагыг хангах, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах шаардлагад нийцүүлэн гаргах үүрэг хүлээнэ.

Түүнчлэн гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй хувь байх шаардлагыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай. Энэ нь улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн нөөцийг урьдчилан бүрдүүлэх, сонгон шалгаруулах ажиллагаагаа шинэ зохицуулалтад нийцүүлэхийг шаардана.

Сонгуулийн байгууллага нь нэр дэвшигчийг бүртгэх шатанд холбогдох хуульд заасан шаардлагын биелэлтийг шалгах боломжтой. Тухайлбал, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулсан эсэх,

тухайн тойрогт нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн хүйсийн төлөөллийн хувь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана. Мөн хуулийн төслийн 32.1.10, 32.1.11-д заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэ нь шинэ байгууллага, тогтолцоо, бүртгэлийн систем бий болгохыг шаардахгүй бөгөөд одоо хэрэгжиж байгаа нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх боломжтой. Харин шинэ зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэхийн тулд Сонгуулийн ерөнхий хорооноос нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой журам, зааврыг шинэчлэх, сонгуулийн хороодод арга зүйн зөвлөмж хүргүүлэх, хяналт шалгалтын ажиллагааг зохион байгуулах шаардлага үүснэ.

Санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын боломж:

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улс төрийн нам болон сонгуулийн байгууллагын үндсэн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг шинээр бий болгох шаардлагагүй. Улс төрийн намууд нэр дэвшигч сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх дотоод ажиллагаагаа шинэ шаардлагад нийцүүлэх замаар хэрэгжүүлэх боломжтой.

Сонгуулийн байгууллагын хувьд нэр дэвшигчийн бүртгэл, баримт бичгийн хяналт шалгалтыг одоо байгаа хүний нөөц, зохион байгуулалтын хүрээнд гүйцэтгэх боломжтой.

Санхүүгийн хувьд шинэ байгууллага байгуулах, орон тоо нэмэгдүүлэх, тусгай мэдээллийн систем шинээр нэвтрүүлэх зайлшгүй шаардлага хуулийн төслөөс шууд үүсэхгүй.

<u>Шилжилтийн хугацаа:</u> Хуулийг 2028 оны ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр тогтоож байгаа нь улс төрийн намуудад:

- дотоод дүрэм, журмаа нийцүүлэх;
- эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчийн нөөц бүрдүүлэх;
- нэр дэвшигчийг сонгон шалгаруулах;
- сургалт, улс төрийн манлайллын хөтөлбөр хэрэгжүүлэх;
- сонгуулийн бэлтгэлээ хангах хугацаа олгоно.

Мөн Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуулийн хороодод хуульд нийцүүлэн холбогдох журам, зааврыг шинэчлэх, нэр дэвшигч бүртгэх ажиллагааны бэлтгэлийг хангах, сонгуулийн хороодын ажилтнуудад сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлнэ.

Ийнхүү хуулийн төсөл нь хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээдүүдийг тодорхойлсон бөгөөд одоо байгаа төрийн байгууллага, улс төрийн нам, сонгуулийн зохион байгуулалтын тогтолцоонд тулгуурлан хэрэгжих боломжтой байна. Гэхдээ нэр дэвшигчийн хүйсийн төлөөллийн шаардлага, нэрийн жагсаалтын дараалал, бүртгэхээс татгалзах үндэслэлийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхийн тулд холбогдох

журам, зааврыг шинэчлэх, сургалт зохион байгуулах, зохион байгуулалтын бэлтгэл хангах шаардлагатай.

Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа бөгөөд тэдгээр этгээдийн одоо байгаа чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтад тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой гэж үзэв. Харин хэрэгжилтийн үр нөлөөг хангахын тулд сонгуулийн байгууллагын арга зүйн бэлтгэл, улс төрийн намуудын нэр дэвшигч сонгон шалгаруулах чадавхыг урьдчилан бэхжүүлэх шаардлагатай тул хуулийн төсөл нь практикт хэрэгжих боломжийн шалгуурыг хангаж байна гэж дүгнэв.

4.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдэд ойлгомжтой, тодорхой, логик дараалалтай эсэхийг шалгав.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 29.4, 29.5, 32.1.10, 32.1.11 дэх хэсгийг шинээр нэмэхээр тусгасан бол 2 дугаар зүйлд одоо мөрдөж буй 29.2 дахь хэсгийн “20-оос” гэсэн тоон үзүүлэлтийг “40-өөс” болгон өөрчлөхөөр тодорхой томьёолсон. Мөн 3 дугаар зүйлд хуулийг 2028 оны ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Уг өөрчлөлт, нэмэлтээр:

- 29.2 дахь хэсэгт улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд тавих хүйсийн төлөөллийн доод хувийг 20-оос 40 хувь болгон нэмэгдүүлэх;
- 29.4 дэх хэсэгт нам, эвслээс тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах;
- 29.5 дахь хэсэгт гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн хүйсийн төлөөлөлд 40 хувийн доод шаардлага тогтоох;
- 32.1.10 дахь хэсэгт 29.2-т заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд нийт нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл нэмэх;
- 32.1.11 дэх хэсэгт 29.4, 29.5-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл нэмэх;
- хуулийн шинэ зохицуулалтыг 2028 оны ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр тогтоох зохицуулалтыг тусгасан байна.

Ингэснээр нэр дэвшүүлэх ажиллагаанд хүйсийн төлөөллийг хангах, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг бүрдүүлэх, сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн хүйсийн харьцааг зохицуулах, эдгээр шаардлагын биелэлтийг нэр дэвшигч бүртгэх шатанд хянах эрх зүйн зохицуулалтыг харилцан уялдаатайгаар бүрдүүлэх зорилготой байна.

Хуулийн төсөлд нэр томьёоны хувьд шинээр ойлголт бий болгоогүй бөгөөд одоо мөрдөж буй хуулийн нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Гэхдээ шинээр нэмэгдэж буй зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэхэд дараах асуудлыг тодорхой болгох шаардлагатай.

<u>Нэгдүгээрт,</u> 29.5 дахь хэсгийн томьёолол. “Нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна” гэсэн найруулга нь эрэгтэй, эмэгтэй хүйсийн төлөөлөл тус бүр 40-өөс доошгүй байх шаардлага тавьж байгаа эсэх, эсхүл аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй байхыг шаардаж байгаа эсэх талаар

хоёрдмол ойлголт үүсгэж болзошгүй. Иймд зохицуулалтын зорилгыг нэг мөр ойлгогдохуйц байдлаар томьёолох шаардлагатай.

Хоёрдугаарт, 29.4 дэх хэсгийн хэрэгжилт. Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах шаардлагыг хэрэгжүүлэхдээ жагсаалтын эхний байрыг аль хүйсийн нэр дэвшигчээс эхлүүлэх, нэр дэвшигчийн бүртгэл өөрчлөгдөх, нэр дэвшигч татгалзах тохиолдолд жагсаалтын дарааллыг хэрхэн хадгалах зэрэг асуудал тодорхой байх шаардлагатай.

Гуравдугаарт, 32.1.10, 32.1.11 дэх хэсгийн зохицуулалт. Нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд “нийт нэр дэвшигчийг” бүртгэхээс татгалзах зохицуулалтын хамрах хүрээ, мөн 29.4, 29.5-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ямар нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах нь тодорхой байх шаардлагатай. Эдгээр үндэслэл, түүний эрх зүйн үр дагаврыг ойлгомжтой, нэг мөр хэрэглэх боломжтой байдлаар томьёолох нь сонгуулийн байгууллагаас хууль хэрэглэхэд үүсэх зөрүүтэй тайлбар, маргаанаас сэргийлэх ач холбогдолтой.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд дагаж мөрдөх хугацааг тусгайлан заасан нь улс төрийн намууд болон сонгуулийн байгууллагад шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх бэлтгэл хангах хугацааг тодорхой болгож байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалтын үндсэн зорилго, агуулга, хэрэгжүүлэх үе шат нь ойлгомжтой боловч 29.5 дахь хэсгийн хүйсийн төлөөллийн хувь хэмжээг тооцох агуулга, 29.4 дэх хэсгийн нэрийн жагсаалтын дараалал, 32.1.10, 32.1.11 дэх хэсгийн бүртгэхээс татгалзах үндэслэл, хамрах хүрээг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Эдгээр асуудлыг нарийвчлан зохицуулснаар хуулийн төслийн зохицуулалт нь ойлгомжтой, тодорхой, хоёрдмол утгагүй болж, ойлгомжтой байдлын шалгуурыг бүрэн хангах боломжтой гэж дүгнэв.

4.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төсөл нь иргэд, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн байгууллагад хэрхэн нөлөөлөх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд үндэслэлгүй хязгаарлалт бий болгох эсэхийг үнэлэв.

Иргэдэд үзүүлэх нөлөө:

Хуулийн төсөл нь иргэдийн сонгох эрхийг өөрчлөхгүй. Иргэн санал өгөх, нэр дэвшигч сонгох, сонгуульд оролцох эрхээ хэвээр эдэлнэ. Харин нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, сонгуулийн тойрогт хүйсийн төлөөллийн доод шаардлага тогтоох зохицуулалт нь сонгогчдод сонголтын илүү тэнцвэртэй боломж бүрдүүлэх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нэр дэвшигчид үзүүлэх нөлөө:

40 хувийн квот нь аль нэг хүйсийн иргэнийг сонгогдох эрхээс шууд хасах зохицуулалт биш бөгөөд нам, эвслээс нэр дэвшүүлэх шатанд хүйсийн төлөөллийн доод шаардлага тогтоож байгаа зохицуулалт юм.

Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай тойрогт хүйсийн

төлөөллийн доод шаардлага хангах зохицуулалт нь нэр дэвшигчдийн нэр дэвших боломж, жагсаалтад эзлэх байрлалд нөлөөлнө. Гэхдээ энэ нь нэр дэвшигчийн мэргэжил, ур чадвар, улс төрийн үзэл баримтлал, бусад хууль ёсны шаардлагыг өөрчлөхгүй бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн улс төрийн оролцооны бодит тэгш боломжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Улс төрийн нам, эвсэлд үзүүлэх нөлөө:

Нам, эвсэл нэр дэвшигчээ тодруулахдаа одоогийн 20 хувийн шаардлагатай харьцуулахад илүү өндөр квот хангах, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийн доод шаардлагыг хангах үүрэг хүлээнэ.

Энэ нь нам, эвслийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээний зохион байгуулалтын өөрчлөлт шаардах боловч намын улс төрийн үйл ажиллагаа явуулах, сонгуульд оролцох эрхийг үгүйсгэхгүй. Харин нэр дэвшүүлэх ажиллагааг хүйсийн тэгш төлөөллийг хангах зарчимд нийцүүлэх шаардлага бий болгоно.

Сонгуулийн байгууллагад үзүүлэх нөлөө:

Сонгуулийн байгууллага нэр дэвшигч бүртгэх үед 29.2, 29.4, 29.5-д заасан шаардлагын биелэлтийг шалгаж, хуульд заасан үндэслэл бий болсон тохиолдолд 32.1.10, 32.1.11-д заасан бүртгэхээс татгалзах зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Энэ нь сонгуулийн байгууллагын одоо хэрэгжүүлж буй нэр дэвшигч бүртгэх чиг үүрэгтэй уялдах бөгөөд шинэ чиг үүрэг, байгууллага бий болгохгүй. Харин нэр дэвшүүлэх ажиллагааны журам, нэрийн жагсаалтын дараалал, хүйсийн төлөөллийн хувийг шалгахтай холбоотой хяналтын ажиллагааг шинэ зохицуулалтад нийцүүлэх шаардлагатай.

Эрх, хууль ёсны ашиг сонирхолд үзүүлэх нөлөө:

Хуулийн төсөл нь улс төрийн нам, эвслийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд тодорхой шаардлага тавьж байгаа боловч энэ нь хүйсийн тэгш төлөөллийг хангах, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцооны тэгш боломжийг бүрдүүлэх зорилготой байна. Иймд тавьж буй шаардлага нь хуулийн төслийн зорилготой уялдсан, сонгуульд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хязгаарлахад чиглээгүй зохицуулалт гэж үзэх боломжтой.

Иймд хуулийн төсөл нь иргэдийн сонгох эрхийг хязгаарлахгүй бөгөөд улс төрийн оролцооны тэгш боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Харин нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл, хамрах хүрээг тодорхой болгож, эрхэд үзүүлэх нөлөөлөлтэй нь уялдуулан зохицуулсан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуурыг хангана гэж үзэв.

4.5. Зардал:

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөв, орон нутгийн төсөв, улс төрийн нам, эвсэл, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэх эсэхийг үнэлэв.

Хуулийн төсөл нь:

- шинэ байгууллага байгуулахгүй;
- шинэ орон тоо бий болгохгүй;
- шинэ төрийн үйлчилгээ бий болгохгүй;
- төрийн албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэхгүй;
- сонгуулийн тогтолцоог өөрчлөхгүй. Иймд улсын төсөвт их хэмжээний шууд нэмэлт зардал үүсэхгүй.

Сонгуулийн байгууллагаас нэр дэвшигч бүртгэх ажиллагаанд ашиглаж байгаа мэдээлэл, бүртгэлийн системд шаардлагатай тохируулга хийх зардал гарч болох боловч энэ нь одоо байгаа сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Улс төрийн нам, эвсэлд үзүүлэх нөлөө: Нам, эвсэл нэр дэвшүүлэх үйл ажиллагаагаа зохион байгуулахтай холбоотой тодорхой хэмжээний нэмэлт зардал гарах боломжтой боловч энэ нь хуулиар тогтоосон татвар, төлбөр, хураамжийн шинжтэй зардал биш.

Иргэдэд үзүүлэх нөлөө: Иргэдэд нэмэлт татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний төлбөр бий болгохгүй.

Хуулийн төсөл нь улсын төсөв болон иргэдэд мэдэгдэхүйц шууд санхүүгийн ачаалал үүсгэхгүй бөгөөд зардлын шалгуурын хувьд хэрэгжих боломжтой байна.

4.6. Харилцан уялдаа:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, зүйл, заалтын хооронд зөрчил, давхардал, хийдэл үүсгэж байгаа эсэхийг шалгав.

Монгол Улсын Үндсэн хуультай нийцэх байдал: Хуулийн төсөл нь хүнийг хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцнэ.

Жендэрийн квот нь сонгох эрхийг хязгаарлах бус, улс төрийн шийдвэр гаргах түвшинд тэгш оролцоог бодитой хангах зорилготой тусгай арга хэмжээний шинжтэй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуультай нийцэх байдал: Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах зорилгоор улс төрийн намын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байлгах зохицуулалттай уялдана.

Улс төрийн намын тухай хуультай нийцэх байдал: Улс төрийн намын удирдах болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүн дэх жендэрийн төлөөллийн 40 хувийн шаардлагатай бодлогын хувьд уялдана.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуультай нийцэх байдал: Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2028 оны ээлжит сонгуулиар аль нэг хүйсийн нэр

дэвшигчийн 40 хувийн доод шаардлагыг тогтоосон зохицуулалттай орон нутгийн сонгуулийн зохицуулалтыг уялдуулна.

Хуулийн төсөл нь Үндсэн хууль болон жендэрийн тэгш байдал, улс төрийн оролцоотой холбоотой бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд харилцан уялдааны шалгуурыг хангаж байна.

ТАВ. ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Үнэлгээний үр дүнд хуулийн төслийн хүрээнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэхэд аль нэг хүйсийн төлөөллийн доод хувийг 20-оос 40 хувь болгон нэмэгдүүлэх;
- нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах замаар нэр дэвшүүлэх ажиллагаанд хүйсийн тэгш төлөөллийг хангах;
- гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нэр дэвшүүлэхэд хүйсийн төлөөллийн доод шаардлага тогтоох;
- нэр дэвшүүлэх болон нэр дэвшигчдийн нэрийн жагсаалт, хүйсийн төлөөлөлд тавигдах шаардлагын биелэлтийг хангах зорилгоор нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлэх;
- улс төрийн шийдвэр гаргах түвшний жендэрийн төлөөллийг сайжруулах;
- үндэсний болон орон нутгийн сонгуулийн жендэрийн квотын бодлогын уялдааг хангах;
- эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх;
- сонгуульд оролцогч талуудад хүйсийн тэгш төлөөллийг хангах эрх зүйн шаардлага бий болгох боломжтой байна.

Хуулийн төсөл нь шинэ байгууллага байгуулах, шинэ орон тоо бий болгох, шинэ төрийн үйлчилгээ бий болгох, сонгуулийн тогтолцоо, мандатын хуваарилалтыг өөрчлөх шаардлага үүсгэхгүй бөгөөд одоо байгаа сонгуулийн зохион байгуулалтын тогтолцоо, нэр дэвшигч бүртгэх ажиллагаанд тулгуурлан хэрэгжих боломжтой. Улсын болон орон нутгийн төсөвт мэдэгдэхүйц шууд нэмэлт зардал үүсгэхгүй

Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.2 дахь хэсгийн “20-оос” гэснийг “40-өөс” болгон өөрчлөх, 29.4, 29.5 дахь хэсгийг шинээр нэмэх, мөн 32.1.10, 32.1.11 дэх хэсэгт нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл нэмэх нь орон нутгийн Хурлын сонгуульд хүйсийн тэгш төлөөллийг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгод нийцсэн, практикт хэрэгжүүлэх боломжтой зохицуулалт гэж дүгнэв.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Үр нөлөөний үнэлгээний дүнд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан 20 хувийн квотыг 40 хувь болгон нэмэгдүүлэх зохицуулалтыг хэвээр хадгалах. Энэ нь орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх ажиллагаанд хүйсийн тэгш төлөөллийг нэмэгдүүлэх, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог бодитой нэмэгдүүлэх зорилгод нийцнэ.

2. Хуулийн төслийн 29.4 дэх хэсэгт тусгасан нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах зохицуулалтыг хэвээр хадгалах. Ингэхдээ жагсаалтын эхний байрыг аль хүйсийн нэр дэвшигчээс эхлүүлэх, нэр дэвшигчийн бүртгэл өөрчлөгдөх, нэр дэвшигч татгалзах тохиолдолд жагсаалтын дарааллыг хэрхэн хадгалах асуудлыг тодорхой болгох.

3. Хуулийн төслийн 29.5 дахь хэсэгт тусгасан гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийн 40 хувийн доод шаардлага тогтоох зохицуулалтыг хэвээр хадгалах. Гэхдээ “аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй хувь байна” гэсэн томьёоллыг хоёрдмол утгагүй болгож, эрэгтэй, эмэгтэй хүйсийн төлөөлөлд тавих шаардлагын агуулгыг тодорхой болгох.

4. Хуулийн төслийг 2028 оны орон нутгийн Хурлын ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдүүлэхээр төлөвлөж байгаа нь улс төрийн намууд болон сонгуулийн байгууллагад шаардлагатай бэлтгэл хангах хугацаа олгох тул уг зохицуулалтыг хэвээр хадгалах. Энэ хугацаанд улс төрийн намууд дотоод дүрэм, журмаа шинэчлэх, нэр дэвшигчдийн нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах ажиллагаагаа шинэ шаардлагад нийцүүлэх, сонгуулийн байгууллага холбогдох журам, зааврaа шинэчлэх бэлтгэлийг хангах шаардлагатай.

5. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооноос нам, эвслийн нэр дэвшүүлэлтийн баримт бичиг, нэр дэвшигчийн бүртгэлд 29.2, 29.4, 29.5-д заасан шаардлагын биелэлтийг шалгах зохицуулалтыг холбогдох журам, зааварт тусгах. Мөн хүйсийн төлөөллийн хувийг тооцох, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын дарааллыг хянах, шаардлага хангаагүй тохиолдолд бүртгэхээс татгалзах ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах.

6. Хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор сонгуулийн байгууллагын мэдээлэл, бүртгэлийн системд шаардлагатай техникийн тохируулга хийх, сонгуулийн хороодын ажилтнуудад холбогдох сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх. Эдгээр ажлыг сонгуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсөвтэй уялдуулан зохион байгуулах.

7. Улс төрийн намууд 40 хувийн квотыг зөвхөн нэр дэвшигчийн тоогоор хангах бус, эмэгтэй нэр дэвшигчийн сонгогдох боломжийг нэмэгдүүлэх улс төрийн дэмжлэг, сургалт, чадавхжуулалт, санхүүжилтийн бодлоготой уялдуулах. Ингэснээр нэр дэвшигчдийн тоон төлөөллийг нэмэгдүүлэхээс гадна сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрийг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

8. Хуулийн хэрэгжилтийн үр дүнг 2028 оны орон нутгийн сонгуулийн дараа үнэлж, нэр дэвшигчийн жендэрийн бүтэц болон сонгогдсон төлөөлөгчийн жендэрийн бүтцийн зөрүүг судлан, шаардлагатай тохиолдолд цаашдын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Үнэлгээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшин, сонгуулийн тойрог, мандатын тоо, нэр дэвшигчдийн хүйсийн бүтэц, сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн бүтцийг харьцуулан судлах.

9. Хуулийн төслийн хэрэгжилттэй холбоотойгоор улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, сонгогч болон сонгуулийн байгууллагаас гарсан санал, гомдол, маргааныг нэгтгэн дүгнэж, хүйсийн төлөөллийн шаардлага, нэр дэвшүүлэх ажиллагаа, бүртгэхээс татгалзах үндэслэлийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх. Үүний үндсэн дээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, цаашид үүсэж болзошгүй хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авах.

--o0o---